

ДАВТАМЖ

ЗОРИЛГО

**ДАВТАМЖИЙН ТАЛААР
СУДЛАХ**

Давтамжийн тухай мэдэх

Давтамжийн ангиллыг ялгаж
чаддаг болох

Давтамжийг амьдрал ахуйдаа
хэрэглэх

ЗОРИЛТ



Эдлэл юмсын хэлбэрийн элементүүд, байрлал, тоо, хэмжээ, өнгө нь тодорхой зүй тогтлын дагуу давтагдаж буй дарааллыг **давтамж** гэнэ.

Давтамжийг метрийн ба
ритмийн давтамж гэж
2 ангилдаг.

Давтамжийг бид нүдээрээ хараад зогсохгүй мөн сонсголоороо мэдэрч, хүлээн авах боломжтой. Давхиж буй морины туурайн төвөргөөн, бүжгийн хөгжим, галт тэрэгний чимээг сонсоход ритм буюу давтамжийг мэдэрнэ. Учир нь эдгээр авиа, чимээ, цохилт нь нэгэн хэмээр давтагдаж байдаг.

Эдлэл юмсад өнгө, тодорхой бүрдэл хэсэг, зураас, хээ, гадаргуу зэргээр давтамж үүсгэж болно.

Давтамж нь байрлал, чиглэлийн хувьд хэвтээ чиглэлтэй, босоо чиглэлтэй, нэг тийш чиглэсэн /чимэглэлийн тууз/, цацраг хэлбэрийн / ширээний бүтээлэг, малгайны хээ, гэрлийн бүрхүүлийн хээ, унь / байж болно.

Метрийн давтамж:

Давтагдах элементийн хэлбэр,
хэмжээ болон хоорондох зай нь
ижил хэмжээтэй байвал **метрийн**
давтамж байна.

Ритмийн давтамж:

Давтагдах элементийн хэлбэр, хэмжээ болон хоорондох зай нь тодорхой зүй тогтлоор / геометрийн өсөх ба буурах дарааллаар / өөрчлөгдөж байвал **ритмийн давтамж** байна.

БАГИЙН АЖИЛ:

1-р баг: Амьд байгаль

2-р баг: Эдлэл, юмсын дизайн

3-р баг: Уран барилга

4-р баг: Хувцасны загвар

ДАВТАМЖИЙН ТАЛААР СУДАЛЛАА.

Давтамжийн тухай мэдлэгтэй
болсон.

Давтамжийн ангиллыг ялгаж
чаддаг боллоо.

Давтамжийг амьдрал ахуйдаа
хэрэглэх чадвартай болсон.

ГЭРИЙН ДААЛГАВАРТ:

**Давтамжийн жишээ зураг 2-3-ийг
зурах, тайлбарлан бичих**

**Хичээлд
идэвхтэй
оролцсонд
баярлалаа.**